ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
42015 Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, 3 дугаар баг
Утас/Факс: 976-7054 3179
И-мэйл: govisumber@audit.gov.mn

2025.04.22 № 164
танай ______-ны № ______-т

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН
ШИВЭЭГОВЬ СУМЫН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН НӨХӨН
СОНГУУЛЬД ОРОЛЦОХ МОНГОЛ
АРДЫН НАМД

Хандивын тайлангийн дүгнэлт

Шивээговь сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нөхөн сонгуульд оролцох **"Монгол ардын нам"**-аас ирүүлсэн хандивын тайланг Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хянан баталгаажуулж, дүгнэлт гаргалаа.

**Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл**

Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны нөхөн сонгуульд оролцох **"Монгол ардын нам"** нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.3.6, 25.4.6-д заасны дагуу иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандивын тайлангаа мөн хуулийн 37 дугаар зүйлийн 37.8-д заасны дагуу Төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллагад хүргүүлж, дүгнэлт гаргуулах үүргийг хүлээнэ.

Хандивыг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, мөн хуулийн 16 дугаар зүйл, Сангийн сайд 2017 оны 386 дугаар тушаалаар батлагдсан санхүүгийн тайлангийн маягт, зааврын дагуу бэлтгэсэн санхүүгийн тайландаа тусгах үүргийг улс төрийн нам хүлээнэ.

Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газар нь Төрийн аудитын тухай хууль болон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуульд заасны дагуу нөхөн сонгуульд оролцох улс төрийн нам, эвсэлд иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандивын тайланг хянан баталгаажуулж, дүгнэлт гаргана.

Намаас дүгнэлт гаргуулахаар ирүүлсэн хандивын тайланд тусгагдаагүй хандивыг хянан баталгаажуулахгүй бөгөөд түүнээс үүсэх үр дагавар, хариуцлагыг Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газар хүлээхгүй болно.

**Дүгнэлтийн үндэслэл**

Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газар сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нөхөн сонгуульд оролцох **"Монгол ардын нам"**-д иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандивын тайланг Аудитын дээд байгууллагуудын Олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2024 оны А/49 дүгээр тушаалаар батлагдсан зааврыг баримтлан Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.1.1, 55.1.2, 55.1.3, 55.1.4, 55.1.5, 55.1.6, 55.1.7-д нийцэж буй эсэхийг дэмжих нотлох баримт, дүн дүгнэлтийн үндсэн дээр хянан баталгаажуулж, дүгнэлт гаргасан болно.

**Дүгнэлт**

**"Монгол ардын нам"** нь нөхөн сонгуульд тухайн сонгуулийн жилийн өмнөх тайлант жилийн хугацаанд тухайн намд иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандивын тайланд тусгасан нийт 2,000,000 /Хоёр сая/ төгрөгийн хандивыг Улс төрийн намын тухай хуулиар тавьсан шаардлагын дагуу хүлээн авсан байна.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.САРАНТУЯА

422502282

Говьсүмбэр аймгийн Төрийн аудитын газрын 2025 оны
......... дугаар сарын ........-ны өдрийн .......... дугаар албан
бичгийн нэгдүгээр хавсралт
МАЯГТ-1

**Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох нам, эвсэл, бие даан**

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН МОНГОЛ АРДЫН НАМ / нам, эвслийн нэр /

/мян.төг/

| д/д | Иргэний нэр | Хандив өгсөн иргэний мэдээлэл | | | | | | Хандив өгсөн огноо | Хандивын мөнгөн дүн | Хандив хүлээн авсан | | | АНСДИТХ-н сонгуулийн тухай хуулийн | | | | Тайлбар |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Иргэний бүртгэлийн дугаар | Нас | Иргэншил | Хандивын эх үүсвэрийн мэдээлэл | Оршин суугаа хаяг | Утасны дугаар | | | Огноо | Банкны нэр | Дансны дугаар | /Тийм, үгүй / | Тийм бол мөнгөн дүн | Хандив буцаасан дансны дугаар | Буцах хаяг тодорхойгүй хандивыг улсын орлого буюу төрийн санд шилжүүлсэн тохиолдолд огноо, дансны дугаар бичих | |
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | | | 9 | 10 | 11 | 13 | 14 | 15 | 16 | 17 |
| 2024 оны 01 дүгээр сарын 01-нээс 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал хугацаанд | | | | | | | | | | | | | | | | | |
| 1 | Батцэнд Ганзориг | 420460770457 | 42 | Монгол | цалин | ГСА, Сүмбэр сум, 3-р баг, 1-р байр, 119 тоот | 99908737 | 24.01.26 | 3 000 000 | 24.01.26 | Хаан банк | 5991054279 | тийм | 3 000 000 | 5990161893 | | Хүнээр дамжуулан намын хорооны дансанд хандив хийлгэсэн байсан. Нэг удаа хандивлаж болох хандивын хязгаар хэтэрсэн тул өөртэй нь утсаар ярьж байгаад тухайн хүний Хаан банкны 5990161893 тоот дансанд нь буцааж шилжүүлсэн болно. |

| | | | | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 2 | Дашдондог Чулуундорж | 420101041328 | 54 | Монгол | цалин | ГСА, Сүмбэр сум, 2-р баг, Цагаан усны 2-6 тоот | 88041909 | 24.04.15 | 2 000 000 | 24.04.15 | Хаан банк | 5991054279 | үгүй | - | - | - | |
| | **ДҮН** | | | | | | | | **5 000 000** | | | | | **3 000 000** | | | |

***Санамж***: *Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.3.6, 25.4.6-т заасан хугацаанд мөн хуулийн 53,54,55 дугаар зүйлд заасан*

Тамга, тэмдэг

Хянасан: ГСА-ын МАН-ын Хорооны дарга /албан тушаал/ — Гомбодоржийн Батсуурь /овог нэр/ — /......................./ /гарын үсэг/

Боловсруулсан: ГСА-ын МАН-ын нябо /албан тушаал/ — Тогмидийн Түмэнбаяр /овог нэр/ — /......................./ /гарын үсэг/